



**ЗООНОЗЫН ӨВЧИН
СУДЛАЛЫН ТӨВ
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ**

ЗӨСТ нь байгалийн голомтот болон зоонозын халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг тандан судлах, хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлэх, зоонозын хүний өвчлөлийн, тохиолдол дэгдэлтийн үеийн эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг.

Түүхэн замнал
Алсын хараа
Эрхэм зорилго
Хамт олон
Үйл ажилллагаа

Хаяг:
Зоонозын өвчин
судлалын төв
Өвөрхангай аймаг
Арвайхээр сум 5-р баг
Утас: 70323379

Цахим шуудан:
Uv_zust@yahoo.com

ТҮҮХЭН ЗАМНАЛ

1932 онд БНМАУ-ын Засгийн Газрын Тэргүүлэгчдийн тогтоолоор Өвөрхангай, Хэнтий, Дорнод, Дорноговь, Өмнөговь, Төв аймгуудын тарваган тахлын голомт бүхий сумдад тарваган тахлын мэдээлэгч санитарын 38 орон тоо баталж гоц аюулт халдварт өвчинтэй тэмцэх байгууллагын анхны суурь тавигдсан.

1928-1954 онд Өвөрхангай аймгийн Баян-Өндөр суманд тарваган тахал өвчний 5 удаагийн голомтонд 30 хүн нас барж байсан тул 1952 онд Баян-Өндөр суманд тарваган тахал эсэргүүцэх станцыг шинээр байгуулсан боловч 1956 онд СНЗ-ын 410 дугаар тогтоолоор татан буулгаж Баянхонгор аймгийн Тарваган тахал эсэргүүцэх станцад хариуцуулан үйл ажиллагаа явуулж байсан.

1981 онд СНЗ-ийн 78-р тогтоолоор аймгийн АЦХСС-ын дэргэд Гоц аюулт халдварт өвчнийг эсэргүүцэн судлах тасаг /ГАХӨЭСТ/ нэртэй байгууллагдаж тасгийн их эмчээр халдвар судлагч их эмч С.Цэдэнбямбаа, нян судлалын лаборант Д.Янжинпүрэв, ариутгагч Ю.Ваанчиг, нярав С.Гаваа, бэлтгэмэлч Я.Занданхүү нар ажиллаж байсан.

ТҮҮХЭН ХӨГЖИЛ



АЛСЫН ХАРАА:

Зоонозын халдварт өвчний судалгаа, шинжилгээ, оношилгоог нарийн мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх

ЭРХЭМ ЗОРИЛГО:

Зоонозын халдварт өвчнөөс хүн амыг эрт сэрэмжлүүлж, хариу арга хэмжээний тусламж үйлчилгээг шуурхай хүргэж, хүний өвчлөл эндэгдлийг бууруулах.

ҮЙЛ АЖИЛЛАГАА:

Манай төв нь аймгийнхаа нутаг дэвсгэрт зоонозын халдварт өвчнүүдийг оношлох, байгалийн голомтын төлөв байдлыг судлан тогтоож, төөрөглөл гаргах, голомтын идэвхийг бууруулах, эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг зохион байгуулах, хүний өвчлөл, өвчний сэжигтэй ба өвчтэй амьтан, мэрэгчийн яаралтай дуудлагын тусламж үйлчилгээг шуурхай зохион байгуулах, халдвар эсэргүүцэх иж бүрэн арга хэмжээ авах, эрүүл мэндийн болон бусад байгууллага, иргэдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээлэл сургалт сурталчилгааг тогтмол хийх зэрэг үйл ажиллагаа явуулж байна.







Тус төвийн хамт олон 1981-2018 онд тарваган тахлын 15 голомтын 20 тохиолдол, боомын 18 голомтын 29 тохиолдол, галзуу өвчний 5 тохиолдол, хачигт энцефалитын 1, хачигт боррелиозын 2, хачигт риккетсиозын хүний өвчлөлийн 38 голомтонд амжилттай ажиллаж голомтыг богино хугацаанд дарсан чадварлаг хамт олон юм.

Мөн энэ хугацаанд БГХШ-ээр тарваган тахлын 170 өсгөвөр, боомын 25 өсгөвөр, ийлдэс судлалын шинжилгээргээр 531 эерэг нэгж материал илрүүлж голомтын төлөв байдлыг тогтоосон.

МАНАЙ ХАМТ ОЛОН:



Манай хамт олонд хүний их эмч - 3, биологич - 2, статистикч бага эмч -1, лаборант - 2 болон бусад мэргэжилтэн, ажилчид ажиллаж байна. Эдгээр эмч мэргэжилтнүүд 100% зоонозын халдварт өвчний чиглэлээр нарийн мэргэжил олгох, дээшлүүлэх дамжаанд хамрагдсан төдийгүй 2010-2014 онд тус төвийн 5 мэргэжилтэн Казахстан улсын Алмата хотын Хөл хориот ба зоонозын халдварт өвчинтэй тэмцэх эрдэм шинжилгээний төвд мэргэжил дээшлүүлэх дамжаанд суралцаад амжилттай ажиллаж байна.

Нийт эмч мэргэжилтний 25% нь магистрын, 50% нь баклаварын, 25% нь мэргэжлийн зэрэгтэй эмч, ажилчид байна.

Манай хамт олон нь Зоонозын халдварт өвчинтэй тэмцэх системийн байгууллагын хэмжээнд ажлаараа 1999, 2002, 2007, 2010, 2014 онд I байр эзэлж бусад жилүүдэд тогтмол II-IV байр эзэлж байсан бахдам амжилттай хамт олон юм.